



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/НН/1

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 17 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222098

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08
дугаар сарын 31 - ны өдрийн
дугаар тушаалын хавсралт



МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Ховд аймаг, Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төв	307/2022	2 жил	2022.09.01	2024.09.01
2.	Дундговь аймаг, Гурван сайхан сумын эрүүл мэндийн төв	308/2022	4 жил	2022.09.07	2026.09.07
3.	Дундговь аймаг, Говь-угтаал сумын эрүүл мэндийн төв	309/2022	2 жил	2022.09.07	2024.09.07
4.	Өмнөговь аймаг, Номгон сумын эрүүл мэндийн төв	310/2022	3 жил	2022.08.31	2025.08.31
5.	Өмнөговь аймаг, Мандал овоо сумын эрүүл мэндийн төв	311/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
6.	Өмнөговь аймаг, Цогтцэций сумын эрүүл мэндийн төв	312/2022	4 жил	2022.08.31	2026.08.31
7.	Өмнөговь аймаг, Ноён сумын эрүүл мэндийн төв	313/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
8.	Сүхбаатар аймаг, Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төв	314/2022	4 жил	2022.09.06	2026.09.06
9.	Увс аймаг, Бөхмөрөн сумын эрүүл мэндийн төв	315/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
10.	Увс аймаг, Зүүнхангай сумын эрүүл мэндийн төв	316/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
11.	Увс аймаг, Өмнөговь сумын эрүүл мэндийн төв	317/2022	3 жил	2022.08.31	2025.08.31
12.	Увс аймаг, Хяргас сумын эрүүл мэндийн төв	318/2022	3 жил	2022.08.31	2025.08.31
13.	Увс аймаг, Эбажи ХХК-ийн Эбажи эмнэлэг	319/2022	3 жил	2022.08.31	2025.09.01
14.	Хөвсгөл аймаг, Алаг-эрдэнэ сумын эрүүл мэндийн төв	320/2022	3 жил	2022.09.01	2025.09.01
15.	Хөвсгөл аймаг, Төмөрбулаг сумын эрүүл мэндийн төв	321/2022	2 жил	2022.09.01	2024.09.01
16.	Хөвсгөл аймаг, Ханх сумын эрүүл мэндийн төв	322/2022	3 жил	2022.09.01	2025.09.01